



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чулуут сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/4/СТА-ТТЗ

Хаяг: Архангай аймаг,
Эрдэнэбулган сум. Аймгийн
ЗДТГ-ын байр “А” корпус, 3
давхар зүүн жигүүр.

Цахим хуудас: www.audit.mn

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр
Утас: 70333141 Цахим хаяг: UlambayrD@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Байгалмаа
Утас: 70332860 Цахим хаяг: BaigalmaaT@audit.gov.mn
Аудитор: J.Mungunshagai
Утас: Цахим хаяг: MungunshagaiJ@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын код: АРА-2021/4/СТА-ТТЗ.....	0
1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.5.2 Авлага.....	12
3.5.3 Бараа материал.....	13
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	15
3.5.10 Орлогын данс.....	15
3.5.11 Зардлын данс.....	16
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	16
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	20
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	20
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал...22	22
Дараагийн аудитад сум хөгжүүлэх сангийн талаар, болон орон нутгийн орлогын төлөвлөлтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.....	22
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	23
1. Авлагын данстай холбоотой асуудал:.....	23
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХСан	Орон нутгийн хөгжлийн сан
СХСан	Сум хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Аудитын гэрчилгээ



ЧУЛУУТ СУМЫН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Б.ТУУЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Чулуут сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуут сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.УЛАМБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	576,894.2	667,849.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	97,109.1	70,725.4
33	АВЛАГА	268,320.8	328,048.8
35	БАРАА МАТЕРИАЛ	211,464.2	264,075.7
36	НӨӨЦИЙН БАРАА		5,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,410,586.4	4,355,495.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,410,586.4	4,355,495.6
39200	Биет хөрөнгө	3,291,515.0	4,231,362.6
39300	Биет бус хөрөнгө	119,071.3	124,133.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,987,480.5	5,023,345.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	219.2	6,759.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	219.2	6,759.1
41300	Өглөг	219.2	6,759.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,987,261.3	5,016,586.4
51	Засгийн газрын хувь оролцоо	3,987,261.3	5,016,586.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,772,010.4	1,772,010.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		1,261,748.8
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		19,240.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,101,587.0	849,922.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,113,664.0	1,113,664.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,987,480.5	5,023,345.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,309,710.1	3,121,437.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	81,521.3	150,493.5
110	Орлогын албан татвар	51,343.9	121,030.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	51,343.9	121,030.4
113	Хөрөнгийн албан татвар	2,670.0	3,784.0

118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,507.5	25,679.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	460,787.8	370,895.2
120	Нийтлэг татварын бус орлого	460,787.8	370,895.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,767,401.0	2,600,048.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,149,411.6	2,858,404.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,149,411.6	2,858,404.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,651,700.7	2,726,520.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,567,256.7	1,808,847.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,843.0	225,533.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,019.2	129,688.3
2104	Хангамж, бараа материалын зардал	122,948.3	126,402.6
2105	Нормативт зардал	126,086.1	96,506.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,853.3	16,895.5
2107	Томилолт, зочны зардал	4,272.0	3,752.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,718.9	54,823.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	453,703.2	264,070.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	497,710.8	131,883.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	160,298.5	263,032.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	151,695.0	409,551.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	8,603.6	(146,518.9)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,967,277.2	2,765,751.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	81,521.3	150,493.5
110	Орлогын албан татвар	51,343.9	121,030.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	51,343.9	121,030.4
113	Хөрөнгийн албан татвар	2,670.0	3,784.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,507.5	25,679.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,846.1	6,394.2
1181	Газрын төлбөр	5,930.6	1,512.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	16,730.8	17,772.0

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,354.9	15,209.6
120	Нийтлэг татварын бус орлого	118,354.9	15,209.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,767,401.0	2,600,048.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,739,792.2	2,621,032.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,739,792.2	2,621,032.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,241,014.3	2,518,094.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,566,919.4	1,799,409.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,763.9	234,065.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,638.1	129,582.3
2104	Хангамж, бараа материалын зардал	91,784.8	109,867.2
2105	Нормативт зардал	129,526.4	103,442.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,249.1	25,716.3
2107	Томилолт, зочны зардал	4,272.0	3,596.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,432.3	58,764.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,428.3	53,650.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	498,777.9	102,938.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	227,485.0	144,719.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	200,194.0	99,495.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	200,194.0	99,495.0
2200	Дотоод эх үүсвэрээр	200,194.0	99,495.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-200,194.0	(99,495.0)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-55,000.0	(71,607.9)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	55,000.0	69,300.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	2,307.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-27,709.0	(26,383.7)

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	124,818.1	97,109.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,109.1	70,725.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,987,261.3	3,987,261.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,987,261.3	3,987,261.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-105,145.7	-105,145.7
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	1,280,989.7	1,280,989.7
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-146,518.9	-146,518.9
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,016,586.4	5,016,586.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,931,583.60	2,688,362.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,586,317.30	2,531,762.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,501,693.00	2,460,110.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,778,850.30	1,778,591.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,017.20	232,715.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,471.40	119,779.55
2104	Хангамж, бараа материалын зардал	95,002.80	91,826.57
2105	Нормативт зардал	124,798.80	102,742.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,721.20	22,721.20
2107	Томиллолт, зочны зардал	3,813.60	3,596.60

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,380.60	55,500.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,637.10	52,637.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,624.30	71,652.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,624.30	71,652.35
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,592.20	87,300.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	243,674.10	69,300.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,931,583.60	2,630,445.23
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,872,066.20	1,833,420.52
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	727,865.20	746,181.95
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,589.70	38,962.06
34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНА АС	289,062.50	11,880.70
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	73,100.56
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	15,183.16
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,322.00	1,316.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7.00	7.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	157.00	154.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,001.00	1,001.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	716.00	716.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	285.00	285.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	157.00	154.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,886.5

21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,886.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,886.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,814.7
2105	Нормативт зардал	700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,931.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,323.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,886.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,886.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,143.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	743.4

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Чулуут сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Б.Туул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасах болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 15-аас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэв.

Чулуут сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чулуут сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны зорилго нь Нутгийнхаа байгаль орчинг хамгаалан, хүний ба бизнесийн хөгжлийн таатай орчинг бүрдүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг жигд хөгжүүлсэн, нийгэм эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэх сум болох” зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцөлийг бүрдүүлэх
- ✓ Ажлын байрыг 2-3 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- ✓ Нийгмийн дэд бүтэц, орон сууцны хангамжийн хувийг дээшлүүлэх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чулуут сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Чулуут сумын удирдлагын байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах зарчим алдагдах зэрэг үр дагавартай байна.

Чулуут сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Төсвийн шууд

захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

Чулуут сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад аудитаар илэрсэн алдаа зөрчлийг эс тооцвол дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,751,150.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 37,511.5 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 97,109.1 мянга, эцсийн үлдэгдэл 70,725.4 мянган төгрөг болж 26,383.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
<u>Төрийн сангийн харилца</u>	97,109.1	70,716.1	-26,393.0
<u>Арилжааны банкин дахь харилцах</u>		9.3	9.3
Дүн	97,109.1	70,725.4	-26,383.7
Үүнээс байгууллагын төрлөөр			
Орон нутгийн ерөнхий орлого	24,008.6	55,532.9	31,524.3
Орон нутгийн хөгжлийн сан	13,759.7	14,292.2	532.5
Сум хөгжүүлэх сан	59,340.8	891.0	-58,449.8
Ахуйн үйлчилгээ		9.3	9.3
Дүн	97,109.1	70,725.4	-26,383.7

Эх сурвалж: Чулуут сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 26,383.7 мянган төгрөгөөр буурсан нь сум хөгжүүлэх сангийн үлдэгдэлээс зарцуулсантай холбоотой байна.

3.5.2 Авлага

Авлагын дансны үлдэгдэл 328,048.7 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос 59,727.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
-----------------	-----------------------	------------------------	-------------------------------

Орон нутгийн ерөнхий орлого	83.1	83.1	-
Сум хөгжүүлэх сан	266,983.2	325,763.0	58,779.8
ЭМТөв	1,242.4		(1,242.4)
ИТхурал	12.1	12.1	-
ЗДТГазар		132.1	132.1
Ахуйн үйлчилгээ		1,704.1	1,704.1
Соёлын төв		354.3	354.3
Дүн	268,320.8	328,048.7	59,727.9

Эх сурвалж: Чулуут сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 58,779.8 мянган төгрөгөөр өссөн бол Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны авлаг 83.1 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын авлага 498.5 мянган төгрөгөөр, “Ахуйн үйлчилгээ” ОНӨҮГазрын авлага 1,704.1 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Төсөв байгууллагын авлага нь НДШ-н буцаан олголт, “Ахуйн үйлчилгээ” ОНӨҮГазрын авлага нь түрээслэгдээс авах түрээсийн авлага байна.

Харин СХС нь нийт 106 хүнтэй холбоотой 325,763.0 мянган төгрөгийн зээлийн авлагатайгаас хэвийн зээл 32 хүнтэй холбоотой 124,300.0 мянган төгрөг, хугацаа хэртэрсэн зээл 12 хүнтэй холбоотой 55373.3 мянган төгрөг, чанаргүй зээл 47 хүнтэй холбоотой 146089.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангийн 12 хүнтэй холбоотой 55,373.3 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, 47 хүнтэй холбоотой 146,089.7 мянган төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэлд зөвлөмж хүргүүлээ.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 211,464.2 мянга, эцсийн үлдэгдэл 269,075.6 мянган төгрөг болж, 57,611.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	5,550.4	26,364.9	20,814.5
Эм боох материал	2,558.4	20,103.9	17,545.5
Тусгай зориулалттай материал	2,992.0	6,261.0	3,269.0
Хангамжийн материал	205,913.8	237,710.7	31,796.9
Нөөцийн бараа		5,000.0	5,000.0
Дүн	211,464.2	269,075.6	57,611.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Ахлах сургууль	82,733.2	78,285.9	-4,447.3
ЗДТГ	14,878.9	35,390.0	20,511.1
ИТХ	1,000.0	2,420.0	1,420.0
Соёлын төв	11,982.7	20,837.2	8,854.5
Цэцэрлэг	50,268.1	55,209.4	4,941.3
ЭМТ	37,738.9	60,820.7	23,081.8
Бага сургууль	12,862.4	14,448.7	1,586.3

Ахуйн үйлчилгээ		1,663.7	1,663.7
Дүн	211,464.2	269,075.6	57,611.4

Эх сурвалж: Чулуут сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 29.1 хувь буюу 78,285.9 мянган төгрөг нь Ахлах сургуулийн, 13.2 хувь буюу 35,390.0 мянган төгрөг нь ЗДТГ-ийн, 20.5 хувь буюу 55,209.4 мянган төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 22.6 хувь буюу 60,820.7 мянган төгрөг нь ЭМТөвийн, 7.7 хувь буюу 20,837.2 мянган төгрөг нь Соёлын төвийн, 5.4 хувь буюу 14,448.7 мянган төгрөг нь бага сургуулийн, 0.9 хувь буюу 2,420.0 мянган төгрөг нь ИТХурлын, 0.6 хувь буюу 1,663.7 мянган төгрөг нь Ахуйн үйлчилгээний бараа материалууд байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 393,500.3 мянган төгрөгийн, хандив тусламжаар 15,132.3 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 44,897.3 мянган төгрөгийн материал авсан бөгөөд 395,918.5 мянган төгрөгийн материалыг зарцуулж нийт 269,075.6 мянган төгрөгийн материалын үлдэгдэлтэй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,410,586.3 мянга, эцсийн үлдэгдэл 4,355,495.6 мянган төгрөг болж, 209,861.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,291,515.0	4,231,362.6	939,847.6
Биет бус хөрөнгө	119,071.3	124,133.0	5,061.7
Дүн	3,410,586.3	4,355,495.6	944,909.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Ахлах сургууль	785,977.5	791,076.7	5,099.2
ЗДТГ	1,283,480.3	1,029,838.4	-253,641.9
ИТХ	1,254.9	934.9	-320.0
Соёлын төв	250,042.9	275,975.9	25,933.0
Хүүхдийн цэцэрлэг	627,503.9	614,934.4	-12,569.5
ЭМТ	441,820.2	468,060.6	26,240.4
Бага сургууль	20,506.6	19,903.9	-602.7
Ахуйн үйлчилгээ		1,154,770.8	1,154,770.8
Дүн	3,410,586.3	4,355,495.6	-209,861.5

Эх сурвалж: Чулуут сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 12,195.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хандиваар авсан 39,041.9 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 267,314.2 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 1,280,989.7 мянган төгрөгийн, нийт 1,599,540.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол тайлант онд 49,877.9 мянган төгрөгийн хөрөнгийг актлан, 323,259.2 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Нийт хөрөнгийн 23.6 хувь буюу 1,029,838.4 мянган төгрөг нь ЗДТГазрын, 26.5 хувь буюу 1,154,770.8 мянган төгрөг нь Ахуйн үйлчилгээний, 18.2 хувь буюу 791,076.7 мянган төгрөг нь Ахлах сургуулийн, 14.1 хувь буюу 614,934.4 мянган төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 10.8 хувь буюу 468,060.6 мянган төгрөг нь ЭМТөвийн, 6.3 хувь буюу 275,975.9 мянган төгрөг нь Соёлын төвийн, 0.5 хувь буюу 19,903.9 мянган төгрөг нь Бага сургуулийн хөрөнгүүд эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээ бүрэн нөхсөн нийт 78,749.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
- ЗДТГазрын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 42 нэр төрлийн 131,271.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил байна.
- Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээ бүрэн нөхсөн нийт 32,603.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь ТБОНӨТХ-ийн 31 дэхь заалт, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн тодорхойлолт, НБББББ-ийн Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн горим зэргийг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна. Иймд тухайн хөрөнгүүдийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн холбогдох хууль, стандартын дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмжүүдийг хүргүүлээ.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,987,261.3 мянга, эцсийн үлдэгдэл 5,016,586.4 мянган төгрөг болж, 1,029,325.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯН.ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	1,772,010.4	3,053,000.1	1,280,989.7
Хуримтлагдсан үр дүн	1,101,587.0	849,922.4	-251,664.6
Өмнөх үеийн үр дүн	1,101,587.0	996,441.3	-105,145.7
Тайлант үеийн үр дүн		-146,518.9	-146,518.9
Хөрөнгийн дахин үнэлгээний	1,113,663.9	1,113,663.9	0.0
Дүн	3,987,261.3	5,016,586.4	1,029,325.1

Эх сурвалж: Чулуут сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 1,029,325.1 мянган төгрөгөөр өсч тайлагнагдсан байна.

3.5.10 Орлогын данс

Чулуут сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 3,121,437.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 188,273.1 мянган төгрөгөөр өссөн байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 150,493.5 мянган төгрөг,
2. Татварын бус орлого 370,895.2 мянган төгрөг байна. Үүнээс: төсөвт байгууллагын өөрийн орлого 2,602.5 мянган төгрөг, нийтлэг татварын бус орлого 1,986.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 366,205.8 мянган төгрөг, бусад орлого буюу нэр заагдаагүй бусад орлого 100.0 мянган төгрөг байна.
3. Тусламж санхүүжилтийн орлого 2,600,048.4 мянган төгрөг байна. Үүнээс: Улсын төсвөөс 1,864,706.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 33,886.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 662,493.5 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 38,962.0 мянган төгрөг байна.

3.5.11 Зардлын данс

Чулуут сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 2,858,404.4 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 409,551.5 мянган төгрөг нийт 3,267,955.9 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн (146,518.9) мянган болж өмнөх оноос 155,122.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант жилд 476,261.2 мянган төгрөгийн санхүүжилт, 6,933.8 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн хоорондын тооцоог устгах бичилтээр хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2018 оны 318 тоот тогтоолоор баталсан Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 3.1-д заасны дагуу засаг даргын зөвлөл хуралдаагүй зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлээ.
2. ИТХурал, ЗДТГазар нь тайлант жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй байгаад зөвлөмж хүргүүлээ.
3. Ахлах сургуулийн нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн 48,957.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн.
4. ИТХурлын шатахууны зарцуулалтыг тулган шалгахад 198.5 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтаар зарцуулсан зөрчил илэрсэн төлбөрийн акт тогтоолоо.
5. ЗДТГазар нь тайлант онд сахилгын шийтгэл ногдуулсан 3 албан тушаалтанд үр дүнгийн урамшуулал 580.0 мянган төгрөгийг олгосон зөрчилд аудитаас төлбөрийн акт тогтоолоо.
6. Хүүхдийн цэцэрлэгийн цалингийн давтан тооцооллоор сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд 466.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг, цалингийн нэмэгдлийн тооцооллын зөрүүгээр 1007.9 мянган төгрөгийн, бүх нийтийн хөл хорионы үеэр 1150.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг нийт 2625.4 мянган төгрөгийн цалин урамшууллыг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоон ажилласан байна.
7. ЭМТөв нь түлш шатах тослох материалын зардлаас 2000.0 мянган төгрөгийн түлээ нүүрсийг бэлтгэн нөөцөлсөн, мөн хоол хүнсний зарцуулагдаагүй үлдэгдлээс 731.9 мянган төгрөгийн хүнс бэлтгэсэн зэрэг нийт 2731.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас төлбөрийн акт тогтоосон.
8. ЭМТөв нь сахилгын шийтгэлтэй ажилтанд 283.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

✓ **Орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Орон нутгийн төсвийн орлогыг 63,596.2 мянган төгрөгөөр төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг сумын ИТХурлын 2019.12.11-ний өдрийн 9 тоот тогтоолоор 9,104.6 мянган төгрөгөөр бууруулан 54,491.7 мянган төгрөгөөр анх баталсан байна. Орлого бууруулан баталсан гол шалтгаан нь төсөв байгууллагын өөрийн орлого буюу Ахуйн үйлчилгээний орлого өмнөх жилд сумын ЗДТГазарт төвлөрдөг байсантай холбоотой бөгөөд 2020 онд Ахуйн үйлчилгээний дансанд төвлөрүүлдэг болсонтой холбоотой бууруулан баталсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогыг сумын ИТХурлын 2020 оны 9 дүгээр сарын 24-ны өдрийн 05 тоот тогтоолоор 65,491.7 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Харин гүйцэтгэлээр 115,332.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 176.1 хувиар давуулан биелүүлсэн байна. Тайлангийн хугацаанд газрын төлбөрийн орлого төлөвлөгдөөгүй бөгөөд 130.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 6. Төвлөрүүлэх орлого

/мян. төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	1,800.0	2,336.5	536.5	129.8
2	Шууд бус орлого	15,400.0	37,916.8	22,516.8	246.2
3	Хадгаламжийн хүүгийн орлого	23,700.0	41,016.8	17,316.8	173.1
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	150.0	1,150.7	1,000.7	767.1
5	Бууны татварын орлого	3,720.0	3,784.0	64.0	101.7
6	Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	2,130.0	2,238.4	108.4	105.1
7	Газрын дуудлага худалдааны орлого	2,500.0	1,382.6	(1,117.4)	55.3
8	Газрын төлбөр		130.3		
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	855.0	3,418.6	2,563.6	399.8
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	718.0	737.2	19.2	102.7
11	Байгалийн ургамал ашигласны төлбөр	58.7	58.7	-	100.0
12	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	500.0	485.0	(15.0)	
13	Ойн нөөц ашигласны төлбөр	12,908.0	14,958.3	2,050.3	115.9
14	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	232.0	2,270.0	2,038.0	978.4
15	Төсөвт байгууллагын өөрийн орлого	120.0	1,362.0	1,242.0	1,135.0
16	Хүү торгуулийн орлого	600.0	1,986.9	1,386.9	331.2
17	Нэр заагдаагүй бусад орлого	100.0	100.0	-	100.0
	Дүн	65,491.7	115,332.8	49,710.8	176.1

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч газрын дуудлага худалдааны орлого 1,117.1 мянган төгрөгөөр, ус рашааны төлбөр 15.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. Газрын дуудлага худалдааг цахимаар 2 удаан зохион байгуулсан боловч 1 дуудлага худалдаанд оролцогч иргэн аж ахуй нэгж байгаагүйгээс мөн ус рашааны төлбөр нь ковид-19 цар тахал гарсантай холбоотой рашаан сувилалд амрах иргэдийн тоо багассантай тус тус холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын анхны болон тодотгосон төсөв батлах тухай тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 7. Төсвийн төлөвлөлт

№	Санхүүжүүлэх эх үүсвэр	Анх баталсан мөнгөн дүн	Тодотгон баталсан мөнгөн дүн	Зөрүү
1	Орон нутгийн ерөнхий орлого	54,371.7	65,371.7	11,000.0
2	Төсөвт байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	251,294.1	251,294.1	0.0
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	402,797.0	386,881.0	-15,916.0

4	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	87,832.5	87,832.5	0.0
5	Тусгай зориулалтын шилжүүлэг	2,202,469.6	2,103,625.3	-98,844.3
6	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	14,629.3	24,008.5	9,379.2
7	Урьд оны ОНХС-ийн үлдэгдлээс санхүүжих	13,759.8	13,759.8	0.0
Нийт дүн		3,027,154.0	2,932,772.9	-94,381.1
Байгууллагын нэр				
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	60,656.8	61,156.8	500.0
2	Засаг даргын тамгын газар	411,261.2	415,224.4	3,963.2
3	Орон нутгийн хөгжлийн сан	101,592.3	101,592.3	0.0
4	Сум хөгжүүлэх сан	246,174.1	246,174.1	0.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	467,735.8	437,114.5	-30,621.3
6	Ерөнхий боловсролын сургууль	1,047,647.7	985,116.0	-62,531.7
7	Бага сургууль	143,756.5	139,219.5	-4,537.0
8	Соёлын төв	87,290.4	87,290.4	0.0
9	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	461,039.2	459,884.9	-1,154.3
Нийт дүн		3,027,154.0	2,932,772.9	-94,381.1

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн шууд бус орлогыг 12,400.0 мянган төгрөгөөр нэмж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 145.0 мянган төгрөгөөр, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг 1,255.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Тодотголоор дараах байгууллагуудын зардлыг нэмж баталсан байна. Үүнд:

1. ЗДТГазрын зардлыг 3,963.2 мянган төгрөгөөр,
2. ИТХурлын зардлыг 500.0 мянган төгрөгөөр тус тус нэмсэн байна.

Мөн Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн буюу ЕБСургууль, Бага сургууль, ЭМТөв, СӨБоловсролын байгууллагын үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор хүүхдийн хоол, үдийн цай болон бусад зардлуудыг нийт 98,844.3 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Төсвийн гүйцэтгэл

Чулуут сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 09 тоот тогтоолоор 3,027,154.0 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 05 тоот тогтоолоор ЗДТГ-г 3,963.2 мянган төгрөгөөр, ИТХурлыг 500.0 мянган төгрөгөөр нэмж, СӨБ-г 30,621.3 мянган төгрөгөөр, ЕБС-г 62,531.7 мянган төгрөгөөр, ЭМТөвийг 1,154.3 мянган төгрөгөөр, Бага сургуулийг 4,537.0 мянган төгрөгөөр хасах тодотгол хийж, нийт зардлын хэмжээг 2,932,772.9 мянган төгрөгөөр баталжээ.

Харин аймгийн ИТХ-ын “Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай” 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор ЕБС-ийн зардлыг 6,103.7 мянган төгрөгөөр бууруулж Хүүхдийн цэцэрлэгийг 2,310.8 мянган төгрөгөөр, Бага сургуулийг 2,603.7 мянган төгрөгөөр нэмж сумын нийт зардлыг 2,931,583.6 мянган төгрөгөөр баталсан нь ковид-19 цар тахлын улмаас сургуулийн хүүхдийн үдийн хоол, цайны зардлын санхүүжилтээс Сангийн яам төсөвт зохицуулалт хийсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,931,583.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,586,317.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 101,592.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 243,674.1 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,872,066.2 мянган төгрөг буюу 63.8 хувийг улсын төсвөөс, 727,865.2 мянган төгрөг буюу 24.8 хувийг орон нутгийн төсвөөс, 42,589.7 мянган төгрөг буюу 1.4 хувийг ЭМД-аас, 289,062.5 мянган төгрөг буюу 10.0 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,688,362.6 мянган төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь урсгал зардал 54,554.7 мянган төгрөг, хөрөнгийн зардал 14,292.2 мянган төгрөг өөр хэмнэгдсэн, СХСангийн эргэн төлөлт 174,374.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Тайлант жил ОНХСангийн хөрөнгөөр 7 төсөл, арга хэмжээнд нийт 87,300.0 мянган төгрөг зарцуулагджээ. Үүнд: барилга байгууламжид 66,700.0 мянган төгрөг, тоног төхөөрөмжид 20,600.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 33,143.1 мянган төгрөг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 743.4 мянган төгрөг нийт 33,886.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авсан байна. Үүнээс Эрүүл мэндийн төв 876.2 мянган төгрөг, ЗДТГазар 32,266.9 мянган төгрөг, Ахлах сургууль 743.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 134 мэдээллээс 108 мэдээллийг хугацаанд нь, 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Ахлах сургууль нь тайлант хугацаанд Шилэн дансны хуулийн дагуу 87 мэдээлэл оруулахаас 12 мэдээлэл хугацаа хоцроосонд албан шаардлага хүргүүлсэн.
2. ЭМТөв нь шилэн дансны цахим системд 147 мэдээлэл хугацаанд нь мэдээллэж, 13 мэдээ хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийн огт мэдээлээгүй, 12342.9 мянган төгрөгийн 4 тушаал шийдвэрийг байршуулаагүйд албан шаардлага хүргүүлсэн.
3. Хүүхдийн цэцэрлэг нь шилэн дансны цахим системд 127 мэдээлэл хугацаанд нь мэдээллэж, 22 мэдээллийг хугацаа хоцроосон, 26046,2 мянган төгрөгийн 4 тушаал шийдвэрийг байршуулаагүйд зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.
4. ЗДТГазар нь шилэн дансны сайтад 118 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол 30 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
5. ИТХурлын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг тулган шалгахад 110 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол 35 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсанд албан шаардлага хүргүүлсэн.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитаар 265,184.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт №8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	9,433.9	1	9,433.9			100
Зөвлөмж	2	265,184.1			2	265,184.1	0
Нийт	3	274,618.0	1	9,433.9	2	265,184.1	50

Хүснэгтээс харахад СХСангийн, болон ОНОрлогын 265,184.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

3.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Чулуут сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 7 төсвийн байгууллага, 1 ОНӨҮГазар, 2 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Чулуут сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №9.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо			Аудитын санал дүгнэлтийн төрөл		
	Аудитад хамрагдсан	Үүнээс		Бүгд	Үүнээс	
		Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Ахлах сургууль	1	1		1	1	
Хүүхдийн цэцэрлэг	1	1		1	1	
ЗДТГ	1	1		1	1	
ИТХурал	1	1		1	1	
Эрүүл мэндийн төв	1	1		1	1	

Соёлын төв	1		1			
ОНХС	1		1			
СХС	1		1			
Бага сургууль	1		1			
Ахуйн үйлчилгээ	1	1		1		1
НИЙТ ДҮН	10	6	4	6	5	1

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 төсөвт байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, соёлын төв, Бага сургууль, 2 төсөл санг түүвэрт хамруулсан бол “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГазарт дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

“Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГазрын дүгнэлт өгөхөөс татгалзсан шалтгаанууд:

- Тухайн ОНӨААТҮГазар нь нягтлан бодогчгүй, орлогын дэлгэрэнгүй тайланд зөвхөн харилцахаар орсон орлогоо тусгадаг, бүртгэлийн хяналт сул байгаагаас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт гаргахад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хангалттай ба зохистой нотлох зүйл авч чадаагүй.
- ОНӨААТҮГ-ын 2020 онд үндсэн үйл ажиллагааны орлого, эргэлтийн хөрөнгө болон эргэлтийн бус хөрөнгийг үнэн шудрага илэрхийлсэн эсэхийг тодорхойлох боломжгүйгээс санхүүгийн тайлан бүхэлдээ буруу илэрхийлэгдсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Хэмжилт”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байсан тул санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 348,394.2 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч 10,804.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 291,581.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 39,589.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6,419.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт №10. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчил		Үүнээс				Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахлах сургууль	2	48,957.6			2	48,957.6			1		1	48,957.6
Хүүхдийн цэцэрлэг	5	61,274.8			5	61,274.8	1	2,625.4	1	26,046.2	3	32,603.2
ЗДТГ	6	131,851.2			6	131,851.2	1	580.0	1		4	131,271.2
ИТХурал	3	198.5			3	198.5	1	198.5	1		1	
Эрүүл мэндийн төв	6	104,912.1	1	10,804.3	5	94,107.8	2	3,015.5	1	12,342.9	2	78,749.4
Соёлын төв	1	1,200.0			1	1,200.0			1	1,200.0		
НИЙТ ДҮН	23	348,394.2	1	10,804.3	22	337,589.9	5	6,419.4	6	39,589.1	11	291,581.4

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 142,075.5 мянган төгрөгийн, арвилан хэмнэлттэй холбоотой 6,419.4 мянган төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил 199,899.3 мянган төгрөгийн тус тус илэрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Чулуут сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар шилэн дансны 26 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан, СХСангийн хугацаа хэтэрсэн болон ,чанаргүй 201,463.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрлээ.

Хүснэгт №11 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт			
			Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сум хөгжүүлэх сан	1	201,463.0			1	201,463.0
Нэгдсэн тайлан	1		1			
НИЙТ ДҮН	2	201,463.0	1		1	201,463.0

1. Сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ 124,300.0 мянган төгрөг байгаа бол хугацаа хэртэрсэн зээл 12 хүнтэй холбоотой 55,373.3 мянган төгрөг, чанаргүй зээл 47 хүнтэй холбоотой 146,089.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Аудитаас чанаргүй зээлд зөвлөмж хүргүүлээ.
2. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 134 мэдээллээс 108 мэдээллийг хугацаанд нь, 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсанд албан шаардлага хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитад сум хөгжүүлэх сангийн талаар, болон орон нутгийн орлогын төлөвлөлтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.



4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал:

- 1.1. **Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн авлагын хэмжээ 325,763.0 мянган төгрөг байгаа бол хэвийн зээл нь 124,300.0 мянган төгрөг, хугацаа хэртэрсэн зээл 12 хүнтэй холбоотой 55,373.3 мянган төгрөг, чанаргүй зээл 47 хүнтэй холбоотой 146,089.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна
- 1.2. **Эрсдэл:** Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авах. Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Чулуут сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021.03.25			АРА-2021/8/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Чулуут сумын ТЕЗ		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мян төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.		Албан шаардлага		
3	СХСан нь 12 хүнтэй холбоотой 55,373.3 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн, 47 хүнтэй холбоотой 146,089.7 мянган төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна	126.466.1	Зөвлөмж өгөх	Засаг дарга, Санхүү албаны дарга	Б.Туул Ц.Сувдмаа

	ДҮН	126,466.1			